



ТАВАНТОЛГОЙ ХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ

“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 40

Цогтцэций сум

Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн
бичгийн даргыг чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3, Долоогийн 7.18 дахь хэсэг, Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлын 2026 оны 07 дугаар тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын Хоёрын 2.4.1 дахь заалт, 2026 оны 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн, Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргын саналыг хэлэлцээд “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг түр хавсран гүйцэтгэгч Э.Бөхбатыг бичгийн даргын албан тушаалыг түр хавсран гүйцэтгэгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.“Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэгчээр компанийн хуулийн ахлах мэргэжилтэн Бат-Өлзийн Болдбаярыг томилсугай.

3.Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэгч, компанийн хуулийн ахлах мэргэжилтэн Б.Болдбаярт албан тушаал хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг компанийн Гүйцэтгэх захирал (Ш.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд Төлөөлөн Удирдах зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хангаж, нарийн бичгийн даргын эрх, үүргийг хариуцлагатай хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэгч (Б.Болдбаяр)-д үүрэг болгосугай.

5.Э.Бөхбаттай ажил хүлээлцэх үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, холбогдох баримт бичиг, эд хөрөнгийг бүрэн тоолон хүлээж авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэгч (Б.Болдбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Б.МЭНДБАЯР